

**ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ  
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА БӨГӨӨД  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД,  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН  
ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

20 ... оны ... сарын ... өдөр

Дугаар 155, А/11


Улаанбаатар хот

Авлигаас урьдчилан сэргийлэх олон нийтийн  
дэд зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 7, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4, Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 5.4.15, Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор баталсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн "Хоёр"-ийн 2.1.7, "Дөрөв"-ийн 4.1.7.4, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2001 оны 25 дугаар зарлигаар баталсан "Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журам"-ын "Хоёр"-ын 1-ийн 1, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймаг, нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл болон яам, агентлагийн дэргэд авлигаас урьдчилан сэргийлэх үүрэг бүхий "Олон нийтийн дэд зөвлөл"-ийг байгуулан ажиллуулсугай.
2. "Олон нийтийн дэд зөвлөл"-ийн ажиллах байгууллага, гишүүний тоог нэгдүгээр, "Олон нийтийн дэд зөвлөлийн ажиллах журам"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг салбарын Сайд, агентлагийн дарга наарт зөвлөж, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, "Олон нийтийн дэд зөвлөл"-ийн гишүүдэд тус тус үүрэг болгосугай.

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ  
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГА БӨГӨӨД ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД

  
С.БЯМБАДОГТ

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮН КОМИССАР



Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, Дотоод хэргийн сайд, Авлигатай тэмцэх газрын даргын 2017 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн 3 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт

**“ОЛОН НИЙТИЙН ДЭД ЗӨВЛӨЛ”-ИЙН АЖИЛЛАХ  
БАЙГУУЛЛАГА, ГИШҮҮНИЙ ТОО**

Нэг. Яам, агентлагийн дэргэд

<i>№</i>	<i>Яам, агентлагийн нэр</i>	<i>Гишүүний тоо</i>
1.	Батлан хамгаалах яам	3
	Зэвсэгт хүчний жанжин штаб	
2.	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	3
	Биетийн тамир, спортын газар	
	Соёл урлагийн газар	
3.	Барилга, хот байгуулалтын яам	3
	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	
4.	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	3
	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	
	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	
5.	Стандарт, хэмжил зүйн газар	3
	Үндэсний хөгжлийн газар	
	Онцгой байдлын ерөнхий газар	
	Тагнуулын ерөнхий газар	0
6.	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	3
7.	Сангийн яам	3
8.	Гаалийн ерөнхий газар	3
9.	Татварын ерөнхий газар	3
10.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	3
	Мал эмнэлэг, үржлийн газар	
11.	Гадаад харилцааны яам	3
12.	Эрчим хүчний яам	3
	Хууль зүй, дотоод хэргийн яам	
	Архивын ерөнхий газар	
13.	Гадаадын иргэн, харьяатын газар	6
	Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар	
	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	
	Хил хамгаалах ерөнхий газар	
14.	Цагдаагийн ерөнхий газар	3
15.	Үүл уурхай, хүнд үйлдвэрийн яам	3
	Ашигт малтмал, газрын тосны газар	
16.	Зам, тээврийн хөгжлийн яам	3
	Иргэний нисэхийн ерөнхий газар	
17.	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	3
	Цаг уур, орчны шинжилгээний газар	
18.	Эрүүл мэндийн яам	3
19.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	3

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар	
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	
Нийт - 19	60

Хоёр. Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн дэргэд

<i>№</i>	<i>Аймаг, нийслэл, сум, дүүрэг</i>	<i>Гишүүний тоо</i>
1.	Архангай	3
2.	Баян-Өлгий	3
3.	Баянхонгор	3
4.	Булган	3
5.	Говь-Алтай	3
6.	Говь-Сүмбэр	3
7.	Дархан-Уул	3
8.	Дорнод	3
9.	Дундговь	3
10.	Дорноговь	6
11.	Завхан	6
12.	Орхон	3
13.	Өвөрхангай	3
14.	Өмнөговь	9
15.	Сүхбаатар	3
16.	Сэлэнгэ	6
17.	Төв	3
18.	Увс	3
19.	Ховд	3
20.	Хөвсгөл	3
21.	Хэнтий	3
22.	Нийслэл	30
	Нийт - 22	108

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, Дотоод хэргийн сайд, Авлигатай тэмцэх газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн 13 дугаар хамтарсан тушаалын хөөрдугаар хавсралт.

## АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ОЛОН НИЙТИЙН ДЭД ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмаар "Олон нийтийн дэд зөвлөл" /цаашид "Дэд зөвлөл" гэх/-ийн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалт болон холбогдох бусад асуудлыг зохицуулна.

1.2 Дэд зөвлөл нь Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажиллагаанд иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний идэвх санаачилгыг өрнүүлэх, хөхиулэн дэмжих, төрийн байгууллагын үйл ажиллагаа, албан тушаалтны ёс зүйд хяналт тавих зорилгыг хэрэгжүүлнэ.

1.3 Дэд зөвлөл нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийг баримтална.

1.4 Дэд зөвлөлийн гишүүн /цаашид "Гишүүн" гэх/ хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэхдээ байгууллагын нууцад хамаарахаас бусад буюу Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасны дагуу нээлттэй байвал зохих бүх төрлийн мэдээлэлтэй танилцах, мэдээлэл авах эрхтэй байна.

1.5 Дэд зөвлөлийн гишүүд энэхүү журмын 3.1.1, 3.1.2, 3.1.3 дахь хэсэгт зааснаас бусад асуудлаар байгууллагын үйл ажиллагаанд шууд оролцох, хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

1.6 Нийтийн албаны удирдлагаас Нийтийн албанаас нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу томилсон эрх бүхий албан тушаалтны мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих, тайлاغнах ажилд хөндлөнгөөс оролцохгүй ба авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, сургалт сурталчилгааны ажлыг хамтран зохион байгуулж болно.

Хоёр. Зохион байгуулалт, сонгон шалгаруулалт

2.1 Дэд зөвлөл нь яам, агентлаг болон аймаг, нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дэргэд ажиллана.

2.2 Авлигатай тэмцэх газар нь Дэд зөвлөлийн гишүүнээр ажиллах иргэнтэй "Хамтран ажиллах гэрээ" байгуулна. Гэрээнд гүйцэтгэх чиг үүрэг, гишүүний эрх, үүрэг, урамшууллын хэмжээ, ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой асуудлыг тусгана.

2.3 Авлигатай тэмцэх газар Дэд зөвлөлийн гишүүнээр ажиллах иргэнд тавигдах шаардлага, сонгон шалгаруулах хугацааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлана.

2.4 Иргэдээс сонгон шалгаруулалт явуулах ажлын хэсгийг Авлигатай тэмцэх газрын даргын тушаалаар томилж, ажиллуулна.

2.5 Дэд зөвлөлийн гишүүнээр ажиллах иргэн дараахь шаардлага хангасан байна:

2.5.1 тухайн нутаг дэвсгэрт сүүлийн 2 жил байнга оршин сууж байгаа Монгол Улсын иргэн;

2.5.2 дээд боловсролтой, төсөв, санхүү, эдийн засаг, нягтлан бодох Буртгэл, хууль эрх зүй, аудит, хяналт, эд хөрөнгийн үнэлгээ, хяналт шалгалт, инженер техникийн чиглэлээр ажиллаж байсан ажлын туршлагатай байх;

2.5.3 хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагад сүүлийн 2 жилийн хугацаанд хөдөлмөрийн гэрээ болон үр дүнгийн гэрээ байгуулж ажиллаагүй байх;

2.5.4 хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэх байгууллагатай сүүлийн 2 жилийн хугацаанд хамтран ажиллаагүй буюу гэрээний дагуу тодорхой ажил, үйлчилгээ эрхэлж байгаагүй;

2.5.5 хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэх байгууллагаас сүүлийн 2 жилийн хугацаанд хандив, санхүүгийн дэмжлэг, туслалцаа аваагүй, мөн төлөөлөл хэрэгжүүлээгүй байх;

2.5.6 ял шийтгэлгүй, аль нэг намын харьялалгүй байх, намын гишүүн бол гишүүнээс түдгэлзсэн тухай шийдвэр гарсан байх.

2.6 Энэ журмын 2.4 дэхь хэсэгт заасны дагуу томилогдсон ажлын хэсэг тодорхойлолт, дээд боловсролын дипломын хуулбар, хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэх байгууллагад сүүлийн 2 жилийн хугацаанд ажиллаж байгаагүй, хамтран ажиллаагүй, хандив, санхүүгийн тусламж авч байгаагүй, төлөөлөл хэрэгжүүлээгүй тухай баримт, бусад ашиг сонирхлын зөрчилгүйг нотлох баримтыг хянан үзэж, шаардлага хангасан иргэдтэй ярилцлага хийнэ.

2.7 Гишүүн нь Авлигатай тэмцэх газраас олгосон үнэмлэхтэй байна.

Гурав. Үйл ажиллагааны чиглэл

3.1 Дэд зөвлөл дараахь чиглэлээр үйл ажиллагаа явуулна:

3.1.1 Аливаа шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдлыг хангах, албан тушаалтны ёс зүйг дээшлүүлэх, хүнд суртал, чирэгдлийг арилгах, түүнд иргэд, олон нийтийн хяналтыг бий болгох чиглэлээр:

3.1.1.1 Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасны дагуу мэдээллийг нээлттэй болгосон эсэхийг хянах;

3.1.1.2 Хууль тогтоомж, дүрэм, журам зөрчсөн шийдвэр гарсан, эсхүл хууль бус үйл ажиллагаа явуулсан гэж үзсэн тохиолдолд энэ тухай саналаа Авлигатай тэмцэх газарт хянуулахаар хүргүүлэх;

3.1.1.3 Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагчаас гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нехцэлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдэл, зөрчил арилгуулах албан бичгийн мөрөөр зохион байгуулсан ажил, арга хэмжээг хянах;

3.1.1.4 аливаа сонгон шалгаруулалт, хүний нөөц, боловсон хүчиний томилгоотой холбоотой ашиг сонирхлын зөрчил бүхий шийдвэрийг шалгуулах хүсэлтээ Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх;

3.1.1.5 авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн талаар олж мэдсэн үндэслэл бүхий мэдээллийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх;

3.1.1.6 сургагч багшийн эрх олгогдсон тохиолдолд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах, иргэд олон нийтийг оролцуулах

3.1.1.7 Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн аливаа санал, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээ, мэдээллийн тэмдэглэл хөтлөх.

3.1.2 Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн хэрэгжилт, ил тод байдалд иргэд, олон нийтийн хяналтыг бий болгох чиглэлээр:

3.1.2.1 Хууль тогтоомжоор олгогдсон мэдээлэл авах эрхээ эдлэхэд нь иргэд, олон нийтэд туслалцаа үзүүлэх;

3.1.2.2 төсөв, санхүү, төсвийн орлого, зарцуулалт, хандив, зээл тусламж, түүний хуваарилалт, төсөл хөтөлбөр, тэдгээрийн ил тод, нээлттэй байдлыг хангаж байгаа эсэхэд хяналт тавих, шаардах;

3.1.2.3 төсөв, санхүүгийн зарцуулалт, төсвийн хөрөнгөөр хийгдсэн худалдан авах ажиллагаа, түүний журмын хэрэгжилттэй холбоотой ашиг сонирхлын зөрчил бүхий аливаа шийдвэрийн талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх;

3.1.2.4 Шилэн дансны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, зөрчигдсөн гэж үзвэл энэ тухай мэдээллийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх;

3.1.3 Нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэгт иргэд, олон нийтийн хяналт тавих, мэдээлэл авах эрхээ эдлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр:

3.1.3.1 нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг хуульд заасны дагуу үнэн зөв мэдүүлсэн эсэхэд хяналт тавих;

3.1.3.2 нийтийн албан тушаалтан хөрөнгө, орлогын байдлаа үнэн зөв мэдүүлээгүй гэж үзвэл тухайн мэдээллийг шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх;

3.1.3.3 нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлогын байдалд иргэдийн хяналтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн санал, санаачилгыг Авлигатай тэмцэх газарт уламжлах;

3.1.3.4 Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулаагүй, илт ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзсэн этгээдийг томилсон талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх;

3.1.3.5 нийтийн албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх бэлтгэх, оролцохын өмнө ашиг сонирхлыг зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл, тайлбар гаргасан эсэх болон тэдгээрийн нээлттэй байдалд хяналт тавих, холбогдох мэдээллийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх.

#### Дөрөв. Тайллагнах

4.1 Энэ журамд заасны дагуу гүйцэтгэсэн ажлын тайланг улирал тутамд Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ. Авлигатай тэмцэх газар тайлантай танилцаж, цаашид авах арга хэмжээний талаар Дэд зөвлөлийн гишүүнд ажлын чиглэл өгч, арга зүйн удирдлагаар хангана.

4.2 Авлигатай тэмцэх газар Дэд зөвлөлийн үйл ажиллагааг хагас, бүтэн жилээр дүгнэж, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, салбар зөвлөлд тус тус хүргүүлнэ.

## Тав. Бусад

5.1 Дэд зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлэх, арга зүйн удирдлагаар хангах чиглэлээр Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Салбар зөвлөл, Яам, агентлаг дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.1.1 Дэд зөвлөлийн төрийн байгууллагад байрлаж үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

5.1.2 Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай мэдээ, мэдээллээр хангах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;

5.1.3 Тухайн байгууллагад авлигын эсрэг, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон холбогдох бусад асуудлаар сургалт, сурталчилгээ, соён гэгээрүүлэх ажлыг хамтран зохион байгуулах;

5.1.4 Дэд зөвлөлийн гишүүний үйл ажиллагааны талаар гомдол, санал, хүсэлтийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх;

5.1.5 Хууль тогтоомж, гэрээнд заасан бусад.

5.2 Авлигатай тэмцэх газар дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.2.1 Энэ журамд заасны дагуу Дэд зөвлөлийн гишүүдийг сонгон шалгаруулах;

5.2.2 Дэд зөвлөлөөс ирүүлсэн мэдээллийг хууль тогтоомжид заасны дагуу шалгаж шийдвэрлэх;

5.2.3 Дэд зөвлөлийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

5.2.4 Дэд зөвлөлийн тайланг хүлээн авч, хэлэлцэх;

5.2.5 Гэрээний үр дүнг сар тутам үнэлж, урамшуулал олгох, олгуулахаар санал хүргүүлэх;

5.2.6 Ажил дүгнэх шалгуур үзүүлэлтийг батлах;

5.2.7 Дэд зөвлөлийн үйл ажиллагааг нийтэд мэдээлэх, сурталчлах;

5.2.8 Хууль тогтоомж, гэрээнд заасан бусад.

5.3 Урамшуулал болон Дэд зөвлөл энэ журамд заасан үйл ажиллагаа явуулахтай холбогдон гарах зардлыг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зардлын эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

-----000-----

Оюун - 99767808.

Дамида - 886667022

Норовсамбуу.

АГ-тан Сарданагри - 70112465.